

ЭД ХӨРӨНГӨ БУЦААН ХУДАЛДАЖ АВАХ БОЛЗОЛТОЙ ХИЙСЭН ХУДАЛДАХ ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ

20... оны ..дугаар сарынны өдөр

№...

Улаанбаатар хот

НЭГ. ГЭРЭЭНИЙ ТАЛУУД

1.1. Худалдах, худалдан авах гэрээ \ цаашид “гэрээ” гэх \ - г нэг талаас: “” ХХК- Регистрийн дугаар /цаашид “Худалдагч” гэх/-ийг төлөөлөн Ерөнхий захирал, нөгөө талаас: ”.....” ХХК-/Регистрийн дугаар, /цаашид “Худалдан авагч” гэх/ -ийг төлөөлөн Ерөнхий захирал \цаашид хамтад нь “талууд” гэх\ нар харилцан тохиролцож, Иргэний хууль, Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хууль, Газрын тухай хууль болон талуудын Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын тогтоолыг иш үндэслэн, дараахи нөхцөлтэйгээр байгуулав.

ХОЁР. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- 2.1. Худалдагч нь байрлах жилдтонн үйлдвэрлэх хүчин чадалтай үйлдвэрийг үйлдвэрийн газар, барилга, үндсэн болон туслах тоног төхөөрөмж, контор, дэд бүтэц, шугам сүлээ, өөрөө явах хэрэгсэл, агуулах, автомашины зам, зогсоол, үйлдвэрлэл явуулахад шаардагдах бусад тоног төхөөрөмж, объектууд үйлдвэрийн төсөл, тусгай зөвшөөрөл болон бусад биет бус хөрөнгийг зохиогчийн эрхийн хамт /Үүнд: Байгал орчны ерөнхий болон нарийвчилсан үнэлгээ г.м/ түүнтэй холбоотой баримт бичгийг Худалдагч нь биет байдлын болон эрхийн доголдолгүйгээр Худалдан авагч талд худалдаж шилжүүлэн, актаар хүлээлгэн өгөх, Худалдан авагч нь гэрээнд заасан дээрх эдийн болон эдийн бус хөрөнгийг бүрэн шилжүүлэн хүлээн авч гэрээнд заасны дагуу төлбөрийг худалдагч талынХХК-д төлөх төлбөрийг төлнө.
- 2.2. Худалдагч тал нь энэхүү гэрээний 2.1-т заасан хөрөнгийг худалдан авагч талынХХК-д төлсөн төлбөрийг худалдан авагч талд хугацаанд буцаан төлж барагдуулсаны дараа энэхүү гэрээ байгуулсанаас хойш .. жилийн хугацаанд буцаан худалдан авах эрхтэй болно.
- 2.3. Энэхүү гэрээний 2.1.-т заасны дагуу худалдан авагчид хүлээлгэн өгөх эдийн болон эдийн бус хөрөнгийн жагсаалтыг талууд хавралт №1-ээр батлан гэрээнд хавсаргах бөгөөд энэ нь гэрээний салшгүй нэг хэсэг байна.

ГУРАВ. ХУДАЛДАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 3.1. Энэхүү гэрээний 2.1.-т болон хавсралтад заасан эдийн болон эдийн бус хөрөнгийн эрхийг худалдан авагч талд бүрэн шилжүүлсэнээр гэрээний төлбөрийгХХК-д төлөхийг шаардах, мөн энэхүү гэрээний 2.2-т заасны дагуу хөрөнгийг буцаан худалдахыг шаардах эрхтэй.
- 3.2. Гэрээний салшгүй хэсэг энэхүү гэрээний 2.1.-т болон хавсралтад заасан эдийн болон эдийн бус хөрөнгийн эрх болох холбогдох баримт бичгийг төрийн эрх бүхий байгууллагаар дамжуулан Худалдан авагчид болон түүний заасан хуулийн этгээдийн нэр дээр энэхүү гэрээ баталгаажсанаас хойш 14 /арван дөрөв/ хоногийн дотор актаар болон улсын бүртгэлийн гэрчилгээнүүдийг бүрэн шилжүүлэн өгнө. Шилжүүлэхтэй холбогдсон үйл ажиллагааг бүрэн хариуцан гүйцэтгэнэ.
- 3.3. Хэрвээ шилжүүлж байгаа эдийн болон эдийн бус хөрөнгө түүний баримт бичигт ил, далд биет байдлын болон эрхийн доголдол илэрсэн бол өөрийн зардлаар шинэчлэн сольж өгнө.
- 3.4. Худалдаж буй эдийн болон эдийн бус хөрөнгийн эрхийн зөрчилтэй эсэх талаар холбогдох газруудаас лавлагаа аван худалдан авагч талд хүлээлгэн өгөх үүрэгтэй.
- 3.5. Гэрээ болон хуульд заасан эрх, үүрэг болон гэрээгээр харилцан тохиролцсон үүргийг биелүүлэх.

Үргэлжлэл бий ...